МОНГОЛ УЛСЫН
ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА
ХОЛБООНЫ ЯАМ

Сүхбаатарын талбай 1, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15160
Утас: 33 07 81, Факс: (976-11) 33 07 80,
Цахим шуудан: info@mddc.gov.mn
Цахим хуудас: www.mddc.gov.mn

2024.02.08 № 03/257

танай ______________ -ны № ______________ -т

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАРТ

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичигт хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасныг баримтлан Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2023 оны жилийн эцсийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг, хяналтаас хасуулах саналын хамтаар хүргүүлж байна.

Хавсралт 16 хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Б.БАТЦЭЦЭГ

1924000397

Цахим хөгжил, харилцаа холбооны яамны
Төрийн нарийн бичгийн даргын 20 24.
оны 02. дүгээр сарын 08.-ны өдрийн
03/257. дугаар албан бичгийн хавсралт

# ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМАНД ХАМААРАХ “ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ”-ИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

2023 оны 02 дугаар сарын 06 № Улаанбаатар хот

## НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд хамаарах хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд 2023 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үйл ажиллагааны гүйцэтгэлийн үр дүнг үнэлэх, дүгнэх, зөвлөмж гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2023 оны жилийн эцсийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээг хийхдээ Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

Арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн түвшинг үнэлэн тогтоохдоо дээрх журмын "Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй" болон үр дүн, нотлох баримтад тулгуурлах зарчмыг баримталлаа.

## ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд хамаарах Монгол Улсын 17 хуулийн 51 заалт, Улсын Их хурлын 10 тогтоолын 16 заалт, Улсын Их хурлын Байнгын хорооны 11 тогтоолын 42 заалт, Ерөнхийлөгчийн 6 зарлигийн 8 заалт, Засгийн газрын 38 тогтоолын 51 заалт, Засгийн газрын хуралдааны 48 тэмдэглэлийн 105 заалт, Засгийн газрын 4 албан даалгаврын 7 заалт, Ерөнхий сайдын 3 захирамжийн 3 заалт, Үндэсний аюулгүй байдлын 1 зөвлөмжийн 1 заалт нийт 284 заалт бүхий хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт байгаагаас 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дараах үр дүн гарлаа.

| | | Нийт | МУ-ын хууль | УИХ-ын тогтоол | УИХ-ын байнгын хорооны тогтоол | Ерөнхийлөгчийн зарлиг | ЗГ-ын тогтоол | ЗГ-ын хуралдааны тэмдэглэл | ЗГ-ын албан даалгавар | Ерөнхий сайдын захирамж | ҮАБЗ-ийн зөвлөмж | ҮАБЗ-ийн хуралдааны тэмдэглэл | ЗГ-ын ХЭГ-ын даргын тушаал |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хяналтад авсан нийт шийдвэрийн тоо | | 138 | 17 | 10 | 11 | 6 | 38 | 48 | 4 | 3 | 1 | - | - |
| Хяналтад авсан нийт зүйл, заалтын тоо | | 284 | 51 | 16 | 42 | 8 | 51 | 105 | 7 | 3 | 1 | - | - |
| Бүрэн хэрэгжсэн | 100 | 184 | 34 | 11 | 23 | 5 | 33 | 69 | 5 | 3 | 1 | - | - |
| Хэрэгжих шатанд | 70 | 40 | 3 | 1 | 4 | 2 | 7 | 21 | 2 | - | - | - | - |
| Хэрэгжилт хангалтгүй | 30 | 29 | 8 | - | 3 | 1 | 7 | 10 | - | - | - | - | - |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Хэрэгжээгүй | 0 | - | - | - | - | - | - | - | - | - | - | - | - |
| Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй | Х.Б | 31 | 6 | 4 | 12 | - | 4 | 5 | - | - | - | - | - |
| Биелэлтийн дундаж хувь | | 87,23 | 85,5 | 97,5 | 89 | 83,75 | 85,1 | 86,7 | 91,4 | 100 | 100 | - | - |

1. Бүрэн хэрэгжсэн буюу 100%-ийн биелэлттэй арга хэмжээ -184
2. Хэрэгжих шатандаа буюу 70%-ийн биелэлттэй арга хэмжээ – 40
3. Хэрэгжилт хангалтгүй буюу 30%-ийн биелэлттэй арга хэмжээ – 29
4. Хэрэгжилт байхгүй ажил - 0
5. Хугацаа болоогүй буюу үнэлэх боломжгүй – 31 арга хэмжээ байна.

Хэрэгжилтийн дундаж: 87.23% хувьтай дүгнэгдлээ.

## ГУРАВ. ДҮГНЭЛТ

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн 2023 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар нийт 284 заалтад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ үр дүн суурилсан, нотолгоонд тулгуурласан байхыг шаардаж ажиллаа.

**Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн биелэлтээс тус яаманд хамаарах дараах ажлууд амжилттай сайн хэрэгжсэн байна**. Үүнд:

- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийн биелэлт амжилттай буюу 100 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна. Тодруулбал Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хүрээнд тус яам өөрт хамаарах 68 төрлийн мэдээллийг ил тод байршуулсан. Үүний зэрэгцээ Монгол Улсын Засгийн газар 2023 оныг “Авлигатай тэмцэх жил” болгон зарлаж, авлигатай тэмцэх таван Ш буюу Шүгэл, Шүүр, Шувуу, Шилжүүлэн авах болон Шил ажиллагааг хэрэгжүүлсэн. Иргэдийн мэдээлэл хайх, мэдээлэл хүлээн авах эрхийг хангах, “Шил ажиллагаа”-ны хүрээнд Цахим хөгжил, харилцаа холбооны яам тэргүүлэн ажилласан.

Ингэснээр төрийн байгууллагуудын мэдээллээ нээх үйл явц эрчимжиж, Shilen.gov.mn сайтад нийтэлж эхэлсэн. Шил ажиллагааны гол зорилго бол төрд хэн, хаана, хэзээ, юу хийж байгааг иргэд нь шууд харж хянаж, хулгайг хийх боломжийг технологийн шийдлээр хааж хумих юм. shilen.gov.mn платформыг 2023 оны гуравдугаар сарын 27-ны өдөр “Шилэн” ажиллагааны хүрээнд нээсэн бөгөөд “Таны төр-Та хяна” уриалгийг олон нийтэд дэвшүүлсэн. Уг платформ мэдээлэл хариуцагчдаас ирүүлсэн, хуулиар ил болгох ёстой мэдээллүүдийг нэгтгэн иргэд, олон нийт, хэвлэл мэдээллийнхэнд нэг цонхоор мэдээлэлд хяналт тавих боломжийг олгож буй. Шил ажиллагааны “shilen.gov.mn” системд нийт 39 төрлийн 970,355 нэгж мэдээллийг 2008 – оноос хойших байдлаар түүхчлэн байршуулж, нийт 8,889,892 удаагийн хандалтыг аваад байна. Үүнд:

1.Монгол Улсын тусгай хамгаалалттай газар нутагт эрх бүхий албан байгууллагаас 4,568 га газрыг 2,079 хүн, хуулийн этгээдэд олгосон талаарх мэдээлэл;

2.Хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээний явцад хийгдсэн байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөллийн нийт 15,508 мэдээлэл;

3.Барилга, байгууламжийг ашиглалтад оруулах улсын комиссын 8,437 дүгнэлт, комисст ажилласан 135,102 албан хаагчийн мэдээлэл;

4.Төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой төлөөлөн удирдах зөвлөл бүхий 238 хуулийн этгээдийн 1,634 төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн нэрс, цалингийн мэдээлэл;

5.Төрийн өмчийн 310 объектыг түрээслэж буй 1,572 түрээслэгчийн 2944 түрээсийн мэдээлэл;

6.Монгол Улсын Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар нийт 24 тусгай сан үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тэдгээрийн хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэл, санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний мэдээллийг байршуулсан. Эдгээр тусгай сангаас эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг, зээл, тусламж өгдөг 7 тусгай сан байдаг ба мэдээллийг нээлттэй ил тод байршуулснаар 23.5 тэрбум төгрөг, 1,012,220 ам.долларын эргэн төлөлт хийгдсэн үр дүн гарсан. Үүнд:

ба мэдээллийг нээлттэй ил тод байршуулснаар 23.5 тэрбум төгрөг, 1,012,220 ам.долларын эргэн төлөлт хийгдсэн үр дүн гарсан. Үүнд:

- Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн 2009-2022 оны хооронд нийт 1,099 хүн, хуулийн этгээдэд олгосон 1 их наяд төгрөгийн зээлийн мэдээллийг жагсаалтын хамт;

- Хөдөө аж ахуйг дэмжих сангаас 1994–2022 оны хооронд нийт 9,387 хүн, хуулийн этгээдэд олгосон 183.8 тэрбум төгрөгийн зээлийн мэдээлэл болон 147.9 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдлийн талаарх мэдээллийг жагсаалтын хамт;

- Улсын авто замын сангийн 2008–2023 оны хооронд нийт 107 хуулийн этгээдэд олгосон 540 төсөл, хөтөлбөрийн 220 тэрбум төгрөгийн зарцуулалтын талаарх мэдээллийг жагсаалтын хамт;

-Соёл, урлагийг дэмжих сангийн 2020–2022 оны хооронд нийт 219 хүн, хуулийн этгээдэд олгосон 6,5 тэрбум төгрөгийн зарцуулалтын талаарх мэдээллийг жагсаалтын хамт;

- Кино урлагийг дэмжих сангийн 2023 онд 11 хүн, хуулийн этгээдтэй байгуулсан 1 тэрбум төгрөгийн санхүүжилт, одоо хэрэгжиж байгаа гэрээний мэдээллийг жагсаалтын хамт;

- Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сангийн 2012–2023 оны хооронд гэмт хэргийн хохирогч болсон 468 иргэнд олгосон 2,6 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр, 1,6 тэрбум төгрөгийн авлагын талаарх мэдээллийг жагсаалтын хамт;

- Боловсролын зээлийн сангийн 2007-2023 оны хооронд нийт 1,497 суралцагчид гадаадын зээл, тэтгэлгийн чиглэлээр олгосон 324 тэрбум төгрөгийн санхүүжилт, түүнээс 316 тэрбум төгрөгийн зээлийн мэдээллийг жагсаалтын хамт;

- Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн 2017-2023 оны хооронд давхардсан тоогоор 666 байгууллага, 18,477 суралцагчид олгосон 72.2 тэрбум төгрөгийн зарцуулалтын мэдээллийг жагсаалтын хамт;

- Шинжлэх ухаан, технологийн сангийн 2007–2022 оны хооронд нийт 381 хүн, хуулийн этгээдэд олгосон 2,780 төсөл, хөтөлбөрийн 151.9 тэрбум төгрөгийн зарцуулалтын талаарх мэдээллийг жагсаалтын хамт;

- Байгаль орчин, уур амьсгалын сангийн 2013-2022 оны хооронд 724 хүн, хуулийн этгээдэд олгосон 1,095 төсөл, хөтөлбөрийн 17.7 тэрбум төгрөгийн зарцуулалтын талаарх мэдээллийг жагсаалтын хамт;

- Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сангаас 2009-2023 оны хооронд 2,000 гаруй иргэнд 3.1 тэрбум төгрөгийн тусламж олгосон талаарх мэдээллийг жагсаалтын хамт;

- Нийгмийн халамжийн сангийн 2008-2022 оны хооронд орлого, зарлагын мэдээллийг, 2016-2022 оны хооронд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт, ахмад настанд үзүүлсэн тусламж хөнгөлөлт, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээг үзүүлдэг 967 хуулийн этгээдэд олгосон санхүүжилтийн мэдээллийг жагсаалтын хамт;

- Нийгмийн даатгалын сангийн 2008-2022 оны хооронд орлого, зарлагын мэдээллийг, 2010-2020 оны банканд байршуулсан мөнгөн хөрөнгийн дүн, хүүгийн орлогын мэдээллийг жагсаалтын хамт;

- Хүүхдийн төлөө сангийн 2021-2023 оны хооронд нийт 11 тэрбум төгрөгийн хуримтлалыг үүсгэсэн ба үүнээс 106.7 сая төгрөгийг нийт 45 хүүхдэд 2 төрлөөр зарцуулсан талаарх мэдээлэл;

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2012-2022 оны хооронд давхардсан тоогоор 1.8 сая иргэнд 628.7 тэрбум төгрөгийн зарцуулалт хийсэн ба үүний 122.2 тэрбум төгрөг нь санхүүгийн дэмжлэг хэлбэрээр олгогдсон, нийт 58.2 тэрбум төгрөгийн авлагатай байгаа талаарх мэдээллийг жагсаалтын хамт;

- Ирээдүйн өв сангийн 2017-2022 оны орлого, зарлагын мэдээлэл;

- Төсвийн тогтворжуулалтын сангийн 2011-2022 оны орлого, зарлагын мэдээлэл;

- Эрүүл мэндийн даатгалын сангийн 2018-2022 оны хооронд орлого, зарлагын мэдээллийг жагсаалтын хамт;

- Эрүүл мэндийг дэмжих сангийн 2008-2023 оны хооронд нийт 3092 хуулийн этгээдэд 1.7 их наяд төгрөгийн санхүүжилт олгосон мэдээллийг жагсаалтын хамт;

- Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2009-2022 оны хооронд 484 хуулийн этгээдээс нийт 47,4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг татан төвлөрүүлж, 155 төсөл,

хөтөлбөрийн санхүүжүүлэлтэд 38.6 тэрбум төгрөг зарцуулсан талаарх мэдээллийг жагсаалтын хамт;

- Спортын дэмжих сангийн 2017–2019 оны хооронд нийт 57 хуулийн этгээдэд олгосон 66 төсөл, арга хэмжээний 4.9 тэрбум төгрөгийн зарцуулалтын талаарх мэдээлэл;

Төрийн байгууллагын нээлттэй, ил тод мэдээлэлд үнэлгээг 7 хоног бүр хийж, үндэсний хэмжээнд "Шилэн Индекс"-ийн үзүүлэлтийг зарласан. Үүнд:

1.Төрийн захиргааны төв байгууллагын хувьд дундаж үзүүлэлт 97%;

2.Төрийн захиргааны байгууллагуудын хувьд дундаж үзүүлэлт 81.53%;

3.Нутгийн захиргааны байгууллагуудын хувьд дундаж үзүүлэлт 90.65%;

4.Нийслэлийн дүүргийн хувьд дундаж үзүүлэлт 96.35%;

5.Төрийн өмчит үйлдвэрийн газар болон бусад төрийн байгууллагууд 40.99%-тай тус тус үнэлэгдсэн.

"Шилэн Индекс"-ийн үзүүлэлтийг анх үнэлэхэд нийт 135 байгууллагын хүрээнд 31%-тай байсан бол одоогийн байдлаар 81.3%-тай болж сайжирсан сайн үр дүн гарсан байна.

- Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 350 дугаар тогтоолын 34 дүгээр хавсралт болгож “Кибер аюулгүй байдлын зөвлөлийн бүрэлдэхүүн”-ийг нэмж баталсан. Зөвлөлийг Монгол Улсын Ерөнхий сайд даргалах бөгөөд дэд даргаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд, Тагнуулын Ерөнхий Газрын дарга ажиллах ба гишүүнд Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга, Харилцаа холбооны зохицуулах хорооны дарга, Цагдаагийн ерөнхий газрын Тэргүүн дэд дарга, Зэвсэгт хүчний Жанжин штабын нэгдүгээр орлогч дарга, Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх "Үндэсний төв", "Нийтийн төв", "Зэвсэгт хүчний төв"-ийн дарга нар болон Үндэсний дата төв УТҮГ-ын захирал, Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн захирал, Нарийн бичгийн даргаар Кибер аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны дарга ажиллахаар бүрэлдэхүүн батлагдсан.

Дээрх ажлын албанд түшиглэн иргэн, хуулийн этгээдийн мэдээллийн систем, мэдээллийн сүлжээнд чиглэсэн кибер халдлага, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох, хариу арга хэмжээ авах, кибер халдлага, зөрчилд өртсөн мэдээллийн системийг нөхөн сэргээхэд дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий “Кибер халдлага зөрчилтэй тэмцэх нийтийн төв” улсын төсөвт үйлдвэрийн газрын дүрэм, зохион байгуулалтын бүтцийг Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 319 дүгээр тогтоолоор батлан үйл ажиллагааг нь жигдрүүлж байна.

- Засгийн газрын тэргүүлэх ач холбогдолтой төсөл арга буюу цахим шилжилт арга хэмжээний хүрээнд Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Эстони улсын сайн туршлагыг судалж Цахим хөгжил, харилцаа холбооны яам болон Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар, “И-Монгол академи” УТҮГ-н бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг байгуулж https://digital.sudalgaa.gov.mn цахим системийг ашиглан 21 аймгийн цахим шилжилтийн бэлэн байдлын судалгааг хийж, Цахим аймаг бодлогын зөвлөмжийг боловсруулан бэлтгэж, зөвлөмжийн дагуу сургалт, семинар зохион байгуулж ажилласан байна.

- Мөн Цахим хөгжил, харилцаа холбооны яамны хувьд 2023 онд Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан "Өргөн нэвтрүүлгийн сүлжээгээр гамшиг болон аюулын дохио сэрэмжлүүлгийг дамжуулах журам", "Төрийн өмчийн радио, телевизийн газрын сүлжээгээр орон даяар болон тухайн орон нутагт дамжуулах өргөн нэвтрүүлгийн радио, телевизийг сонгох шалгуур үзүүлэлт, тавигдах шаардлага”, Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан "Мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх этгээдийг бүртгэх, аудит хийх журам", Радио долгионы тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан "Үндэсний радио давтамжийн хуваарилалтын хүснэгт", Хүний хувийн мэдээллийг хамгаалах тухай хуулийн 23 дугаар зүйлд заасан "Цахим хэлбэрээр боловсруулалт хийх технологийг ашиглан мэдээлэл цуглуулж, боловсруулж, ашиглах үйл ажиллагаанд үнэлгээ хийх журам”, "Хүний эмзэг мэдээлэл, генетик болон биометрик мэдээлэл боловсруулахад баримтлах технологийн аюулгүй байдлын шаардлага, журам" зэрэг захиргааны актуудыг баталсан байна.

Мөн Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас шалтгаалаагүй буюу мэдээлэл хариуцагч байгууллагаас шалтгаалсан хангалтгүй хэрэгжилттэй хэд хэдэн хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт байна.

Тодруулбал Монгол Улсын Их хурлын 2023 оны “Хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээ тухай” 6 дугаар тогтоол, 2023 оны “Нүүрсний тээвэрлэлт, экспорттой

холбоотой асуудлаарх ерөнхий хяналтын сонсголын тайлантай холбогдуулан авах арга хэмжээний тухай" 8 дугаар тогтоол, Засгийн газрын 2023 оны "Шинжлэх ухаан, технологийн салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" 120 дугаар тогтоол гэх мэт тогтоол шийдвэрийн биелэлтүүд хангалтгүйгээс гадна, тус яамны чиг үүрэгт хамаарахгүй байх тул хугацаа болоогүй буюу Х.Б-р тэмдэглэн хяналтаас хасуулах саналыг тусгасан болно.

Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд хамаарах 284 заалтын биелэлтээс хасуулах санал тусгасан 50 заалт байгаа ба үүнээс 32 заалтын хэрэгжилт бүрэн хангагдсан, 18 заалт Цахим хөгжил харилцаа холбооны яамны үндсэн чиг үүрэгт хамаарахгүй тул хэрэгжилтээс хасуулах саналтай байгааг онцлон дурдаж байна.

## ДӨРӨВ. ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ / ЗӨВЛӨМЖ /

1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг гаргахдаа харьяа байгууллагуудын нэмэлт мэдээллийг авч тусгаж хэвших;

2.Тайланг 2000 тэмдэгтээс хэтрүүлэхгүй, зөв бичгийн алдаагүй, тодорхой, ойлгомжтой, эцсийн байдлаар хянагдсан засваргүй тайланг заасан хугацаанд тайлагнаж хэвших;

3.Тайлан нэгтгэлийг хариуцаж буй албан хаагч удирдлагаар баталгаажуулсан эцсийн тайланг өгч хэвших;

4.Бодлогын баримт бичгийн тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу хэрэгжилтийг харгалзан бичсэн тайлан өгч хэвших;

5.Хангалтгүй үнэлгээтэй ажлын биелэлтүүдийг ахиулахад анхаарал хандуулж, 2024 оны төрийн жинхэнэ албан хаагчийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж хэвших;

6.Засгийн газрын 206 дугаар тогтоолоор батлагдсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-д заасан хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан албан хаагчийн эрх үүрэгтэй танилцан хамтран ажиллахыг цаашид анхаарна уу.

Жич: Яамны газар, хэлтсийн дарга нар дээрх зөвлөмжүүдийг хүлээн авч, нэгжийн албан хаагчдадаа танилцуулах, танилцуулсан хугацаанаас хойш холбогдох арга хэмжээг авч ажиллах үүрэгтэй бөгөөд зөвлөмжийг хэрэгжүүлж байгаа эсэхэд Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас төлөвлөгөөт бус хяналт шалгалтын ажлыг хийх болохыг үүгээр мэдэгдэж байна. Мөн эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээнүүдийг хэрхэн ахиулах болон тайлагнах талаар Төрийн захиргааны удирдлагын газрын холбогдох албан хаагч, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын албан хаагчдаас зөвлөгөө, дэмжлэг авч ажиллахыг хүсье.

-оOо-

## ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМНЫ УДИРДЛАГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 02 сарын 06 өдөр Дугаар 01 Улаанбаатар хот

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн
2023 оны жилийн эцсийн биелэлтийн тухай

Цахим хөгжил, харилцаа холбооны яамны "Хууль тогтоомж, тогтоол шийдвэр"-ийн 2023 оны жилийн эцсийн биелэлтийн талаар:

Хурлыг 2024 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 10 цагаас тус яамны "Хурлын танхим"-д эхлүүлж, Төрийн нарийн бичгийн дарга Б.Батцэцэг удирдан явуулав.

Хуралд:

1.Б.Билэгдэмбэрэл /Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга/

2.Ц.Борхүү /Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга/

3.Ц.Эрдэнэбаяр /Төрийн захиргааны удирдлагын газрын дарга/

4.Л.Нямдорж /Хуулийн хэлтсийн дарга/

5.Б.Золбоо /Цахим засаглалын хэлтсийн дарга/

6.Д. Батбаяр /Нийтийн мэдээллийн дэд бүтцийн хэлтсийн дарга/

7.П.Дэлгэрмаа /Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга/

Хэлэлцэж байгаа асуудлуудтай холбогдуулан Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын шинжээч А.Түвшинзаяа оролцов.

Хэлэлцсэн асуудал: Тус яаманд хамаарах хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 284 заалтын хэрэгжилтэд 2023 оны 4 дүгээр улирлын байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг танилцуулах тухай.

СОНССОН нь:

Цахим хөгжил, харилцаа холбооны яамны чиг үүрэгт хамаарах хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 284 заалтын хэрэгжилтэд 2023 оны жилийн эцсийн байдлаар байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийснийг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн шинжээч А.Түвшинзаяа танилцуулав. /Биелэлт, биелэлтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тэмдэглэлийг хавсаргав/

ШИЙДВЭРЛЭСЭН нь:

Нэг.Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар нь 2023 оны жилийн эцсийн байдлаар байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хуулийн хугацаанд хүргүүлэхийг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Ц.Борхүү/-т даалгаж шийдвэрлэв.

Хоёр.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн тайланг тогтоосон хугацаанд тухай бүр тайлагнаж хэвшихийг Төрийн захиргааны удирдлагын газар /Ц.Эрдэнэбаяр/-т үүрэг болгов.

Хурал 10 цаг 30 минутад дуусав.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Б.БАТЦЭЦЭГ

Цахим хөгжил, харилцаа холбооны яамны 2024 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 04/257 дугаартай албан бичгийн хавсралт.

Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн хяналтаас хасуулах санал
2023 оны жилийн эцэс

| Д/Д | Шийдвэрийн д/д | Заалтын д/д | Шийдвэрийн нэр, огноо, дугаар | Холбогдох заалтын агуулга | Хэрэгжилтын явц | Өөрийн үнэлгээ | Хяналтаас хасах саналтай эсэх | Хяналтаас хасах санал |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| Монгол Улсын хууль | | | | | | | | |
| 1 | 3 | 6 | Татварын ерөнхий хууль /шинэчилсэн найруулга/ 2019-03-27 Дугаар 2023_10 | 18.18.6. 18.18.6.ЭНЭ хуулийн 18.15-д заасныг болон автоматаар мэдээлэл харилцан солилцохтой холбоотой үйл ажиллагаг хэрэгжүүлэхэд шаардлагатай гэж үзсэн журам. | Цахим хөгжил, харилцаа холбооны яамны чиг үүрэгт хамаарахгүй тул хасуулах саналтай байна. Тодруулбал Татварын хуулийн 18.17-д "Эрх бүхий этгээд хоорондын хэлэлцээрийн хүрээнд мэдээлэл автоматаар солилцох зорилгоор эрх бүхий этгээд нь шаардлагатай мэдээллийг тогтоосон хугацаанд, тодорхой хэлбэрт нийцүүлж ирүүлэхийг энэ хуулийн 18.1.3-т заасан байгууллагаас шаардаж болно" гэж, мөн 18.18-т "Энэ хуулийн 18.17-д заасныг хэрэгжүүлэх зорилгоор санхүү, төсвийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран дараах журмыг баталж, мөрдүүлж болно" гэж тус тус заасан байх бөгөөд 18.18.6-д заасан журмыг санхүү, төсвийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батлахаар заасан байна. | Х.Б | Тийм | Цахим хөгжил, харилцаа холбооны яамны чиг үүрэгт хамаарахгүй тул хасуулах саналтай байна. Татварын тухай хуулиар санхүү, төсвийн болон хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батлахаар заасан байгааг анхаарч хэрэгжилтээс хасаж өгнө үү. |
| 2 | 5 | 8 | Засгийн газрын тусгай сангийн тухай /Шинэчилсэн найруулга/ 2019-11-13 Дугаар 2020.01.01 | 9.7. Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санг бүрдүүлэх, зарцуулах журмыг Засгийн газар батална. | Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 9.7, Харилцаа холбооны тухай хуулийн 5.1.3-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн 354 дүгээр тогтоолоор "Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санг бүрдүүлэх, зарцуулах журам"-ыг батлсан.<br>линк: https://legalinfo.mn/mn/detail?lawId=16960002809751 | 100% | Тийм | "Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санг бүрдүүлэх, зарцуулах журам"-ыг батлсан тул хэрэгжилтээс хасуулах саналтай байна. |
| 3 | 6 | 9 | Өргөн нэвтрүүлгийн тухай 2019-12-12 Дугаар 2023_10 | 29.1.3. өргөн нэвтрүүлгийн сүлжээгээр дамжуулах гамшгийн болон онцгой байдлын талаар урьдчилан сэргийлэх үеийн мэдээ, мэдээлэл дамжуулах журам боловсруулж, батлах; | Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны А/01 дүгээр тушаалаар батлагдсан.<br><br>Хавсралт : 1 файл | 100% | Тийм | Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны А/01 дүгээр тушаалаар батлагдсан хэрэгжилт 100 хувьтай байх тул хяналтаас хасуулах саналтай байна. |
| 4 | | 10 | | 29.1.4. өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сан бүрдүүлэх, түүнийг зарцуулах журмыг эрх бүхий байгууллагуудтай хамтран боловсруулах; | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 364 дугаартай тогтоолоор журам батлагдсан.<br>Линк: https://legalinfo.mn/mn/detail?lawId=16960414867061 | 100% | Тийм | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 364 дугаартай тогтоолоор журам батлагдсан тул хэрэгжилтээс хасуулах саналтай байна. |
| 5 | | 11 | | 18.2. Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээний зах зээлд шударгаар өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх, зах зээлийн хэт төвлөрөл үүсэхээс сэргийлэх журмыг Зохицуулах хороо батална. | Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 73 дугаар тогтоолоор батлагдсан.<br>https://legalinfo.mn/mn/detail?lawId=16389972057261&type=3 | 100% | Тийм | Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 73 дугаар тогтоолоор батлагдсан тул хэрэгжилтээс хасуулах саналтай байна. |
| 6 | | 12 | | 24.2. Радио, телевизээр дамжуулах аливаа хэлбэрийн зар сурталчилгааны хязгаарлалт, хөтөлбөрийн ивээн тэтгэлт, төлбөрт, захиалгат, теле-худалдааны нэвтрүүлгийн талаарх зохицуулалт хийхтэй холбогдсон журмыг Зохицуулах хороо баталж, хэрэгжилтэд хяналт тавина. | Харилцаа холбооны зохицуулах хорооны 2020 оны 77 дугаар тогтоолоор "Радиогоор нэвтрүүлэх зар сурталчилгааны зохицуулалтын журам", 89 дүгээр тогтоолоор "Телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгааны зохицуулалтын журам" тус тус батлсан.<br>https://legalinfo.mn/mn/detail?lawId=16123495441751 89 дүгээр тогтоолын линк: https://legalinfo.mn/mn/detail?lawId=16123495451291 | 100% | Тийм | Харилцаа холбооны зохицуулах хорооны 2020 оны 77 дугаар тогтоолоор "Радиогоор нэвтрүүлэх зар сурталчилгааны зохицуулалтын журам", 89 дүгээр тогтоолоор "Телевизээр нэвтрүүлэх зар сурталчилгааны зохицуулалтын журам" тус тус батлсан тул хэрэгжилтээс хасуулах саналтай байна. |
| 7 | | 13 | | 28.3. Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сан бүрдүүлэх, түүнийг зарцуулах журмыг батална. | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 364 дүгээр тогтоолоор ӨРГӨН НЭВТРҮҮЛЭГ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ДҮРЭМ, САН БҮРДҮҮЛЭХ, САНГИЙН ХӨРӨНГИЙГ ЗАРЦУУЛАХ ЖУРМЫГ БАТАЛСАН.<br>https://legalinfo.mn/mn/detail?lawId=16960414867061 | 100% | Тийм | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 364 дугаартай тогтоолоор журам батлагдсан тул хэрэгжилтээс хасуулах саналтай байна. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 8 | | 14 | | 30.1. Харилцаа холбооны зохицуулах хорооны бүрэн эрх:30.1.7.өргөн нэвтрүүлгийн үйлчилгээтэй холбогдсон дараах дүрэм, журмыг батлах, хэрэгжилтэд хяналт тавих; 30.1,7.а.хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалахад чиглэсэн радио, телевизийн хөтөлбөрийн дүрэм; 30.1.7.б.өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийн журам; 30.1.7.в.олон суваг дамжуулах үйлчилгээний үндсэн багцын зохицуулалтын журам; | 30.1.7.а. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 62 дугаар тогтоолоор баталсан.<br>https://legalinfo.mn/mn/detail?lawId=16381537306261<br>30.1.7.б. Харилцаа холбооны зохицуулах хорооны 2020 оны 88 дугаар тогтоолоор "Радиогийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага"-ыг баталсан.<br>https://legalinfo.mn/mn/detail?lawId=16123495457411<br>Харилцаа холбооны зохицуулах хорооны 2021 оны 02 дугаар тогтоолоор "Телевизийн үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлага"-ыг баталсан.<br>https://legalinfo.mn/mn/detail?lawId=16147364164751<br>30.1.7.в.Харилцаа холбооны зохицуулах хорооны 2020 оны 62 дугаар тогтоолоор баталсан.<br>//legalinfo.mn/mn/detail?lawId=15710 | 100% | Тийм | Харилцаа холбооны зохицуулах хорооны бүрэн эрх:30.1.7.өргөн нэвтрүүлгийн үйлчилгээтэй холбогдсон дараах дүрэм, журмыг батлах, хэрэгжилтэд хяналт тавих; 30.1,7.а.хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалахад чиглэсэн радио, телевизийн хөтөлбөрийн дүрэм; 30.1.7.б.өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийн журам; 30.1.7.в.олон суваг дамжуулах үйлчилгээний үндсэн багцын зохицуулалтын журмууд батлагдсан тул хэрэгжилтээс хасуулах саналтай байна. |
| 9 | 8 | 16 | Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2020-05-15 Дугаар 2020-05-15 | 8.4. Эрүүл мэндийн цахим бүртгэл, мэдээллийн сангийн өгөгдөл солилцох, хадгалах, хамгаалах, баяжуулах, ашиглах журмыг Засгийн газар батална. | Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4-т Эрүүл мэндийн цахим бүртгэл, мэдээллийн сангийн өгөгдөл солилцох, хадгалах, хамгаалах, баяжуулах, ашиглах журмын төсөлд 2023 оны 12 дугаар сарын 26-ны 01/2340 дугаар албан бичгээр санал хүргүүлсэн.<br>Хавсралт : 1 файл | 100% | Тийм | Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас саналыг хүргүүлсэн тул хэрэгжилтээс хасуулах саналтай байна. Журам батлуулах үүргийг Эрүүл мэндийн яам хүлээж байгаа болно. |
| 10 | | 18 | | 7.1. Кибер аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх, илрүүлэх, хариу арга хэмжээ авах нийтлэг журмыг Засгийн газар батална. | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 224 дүгээр тогтоолоор "Кибер аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх, илрүүлэх, хариу арга хэмжээ авах нийтлэг журам"-ыг баталсан. | 100% | Тийм | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 07-ны өдрийн 224 дүгээр тогтоолоор "Кибер аюулгүй байдлыг хангах, урьдчилан сэргийлэх, илрүүлэх, хариу арга хэмжээ авах нийтлэг журам"-ыг батлагдсан тул хяналтаас хасуулах саналтай байна. |
| 11 | | 19 | | 8.3. Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх журам, аргачлалыг цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тагнуулын байгууллагатай хамтран батална. | Цахим хөгжил, харилцаа холбооны сайд, Тагнуулын Ерөнхий Газрын даргын хамтарсан 2023 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн А/129, А/147 дугаар хамтарсан тушаалаар "Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх журам", "Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал"-ыг тус тус баталж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхээр Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 01/2635 дугаартай албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлээд байна.<br>Хавсралт : 2 файл | 100% | Тийм | Цахим хөгжил, харилцаа холбооны сайд, Тагнуулын Ерөнхий Газрын даргын хамтарсан 2023 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн А/129, А/147 дугаар хамтарсан тушаалаар "Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх журам", "Кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ хийх аргачлал"-ыг тус тус баталсан тул хяналтаас хасуулах саналтай байна. |
| 12 | 10 | 20 | Кибер аюулгүй байдлын тухай 2021-12-17 Дугаар 2021-12-17 | 9.5.. Мэдээллийн аюулгүй байдлын аудит хийх этгээдийг бүртгэх, аудит хийх журмыг цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална. | Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны А/74 дугаар тушаалаар баталсан.<br>Хавсралт : 1 файл | 100% | Тийм | Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны А/74 дугаар тушаалаар баталсан тул хяналтаас хасуулах саналтай байна. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 13 | 21 | | 11.3. Зөвлөлийн бүрэлдэхүүн, дүрмийг Засгийн газар батална | Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 38 дугаар тогтоолоор "Засгийн газрын үндэсний хороо, комисс, үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай" Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн 350 дугаар тогтоолын 34 дүгээр хавсралт болгож "Кибер аюулгүй байдлын зөвлөлийн бүрэлдэхүүн"-ийг нэмж баталсан. Зөвлөлийг Монгол Улсын Ерөнхий сайд даргадах бөгөөд дэд даргаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд, Тагнуулын Ерөнхий Газрын дарга ажиллах ба гишүүнд Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн дарга, Харилцаа холбооны зохицуулах хорооны дарга, Цагдаагийн ерөнхий газрын Тэргүүн дэд дарга, Зэвсэгт хүчний Жанжин штабын нэгдүгээр орлогч дарга, Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх "Үндэсний төв", "Нийтийн төв", "Зэвсэгт хүчний төв"-ийн дарга нар болон Үндэсний дата төв УТҮГ-ын захирал, Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн захирал, Нарийн бичгийн даргаар Кибер аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны дарга ажиллахаар бүрэлдэхүүн батлагдсан.<br>"Кибер аюулгүй байдлын зөвлөлийн дүрэм"-ийг Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн 42 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан.<br>Хавсралт : 2 файл | 100% | Тийм | Зөвлөлийн бүрэлдэхүүн болон дүрэм батлагдсан тул хяналтаас хасуулах саналтай байна. |
| 14 | 23 | | 16.8. Төрийн албан хаагчид гэрчилгээ олгох, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон харилцааг зохицуулах журмыг Төрийн албаны зөвлөлийн саналыг харгалзан цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална. | Төрийн албан хаагчид тоон гарын үсгийн гэрчилгээ олгох, түүнийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох журмыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны А/28 дугаар тушаалаар баталсан.<br>Хавсралт : 1 файл | 100% | Тийм | Төрийн албан хаагчид тоон гарын үсгийн гэрчилгээ олгох, түүнийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох журмыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны А/28 дугаар тушаалаар баталсан тул хяналтаас хасуулах саналтай байна. |
| 15 | 26 | | 31.1.10. тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хувь, хэмжээг зах зээлийн багтаамж, хэрэглэгчийн тоонд үндэслэн тогтоох; | Монгол Улсын Их Хурлын 2022 оны 35 дугаар тогтоолоор зөвшөөрлийн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт болон салбарын хуулийг Зөвшөөрлийн тухай хууль (Шинэчилсэн найруулга)-д нийцүүлэх чиглэлээр хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, холбогдох хуулийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт даалгасны дагуу Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээний 8 хуульд зөвшөөрөл хүссэн өргөдлийг шийдвэрлэх журам, зөвшөөрөл олгох тухай шийдвэр гаргах, зөвшөөрлийн баримт бичиг бүрдүүлэх, зөвшөөрлийн хугацааг сунгах, зөвшөөрлийг дуудлага худалдаа, сонгон шалгаруулалтын журмаар явуулахтай холбоотой зохицуулалтыг оруулсан.<br>Үүний хүрээнд Цахим гарын үсгийн тухай хуульд тоон гарын үсгийн гэрчилгээ олгох үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хувь, хэмжээг зах зээлийн багтаамж, хэрэглэгчийн тоонд үндэслэн тогтоох чиг үүргийг оруулсан ба одоогийн зах зээлд 5 тусгай зөвшөөрөл эзэмшигчээс 2023 оны 10 дугаар сарын байдлаар нийт 809,189 тоон гарын үсгийг олгосон байгаа нь энэ төрлийн үйлчилгээ эрхлэгчийн тоонд хязгаарлалт тогтоох шаардлагагүй байна. | 100% | Тийм | Зах зээлийн багтаамж, хэрэглэгчийн тоо хангалттай тул энэ төрлийн тусгай зөвшөөрөлд хувь хэмжээ тогтоох шаардлагагүй байна. Энэ заалт нь тус яаманд хуулиар олгогдсон чиг үүргийн хүрээнд судалгаанд үндэслэн гаргах шийдвэр бөгөөд тухай бүрд хэрэгжүүлэх зохицуулалт биш тул хэрэгжилтээс хасуулах саналтай байна. |
| 16 | 28 | | 23.3. Энэ хуулийн 23.1-д заасан үнэлгээ хийх аргачлал, журмыг Хүний эрхийн Үндэсний Комиссын саналыг үндэслэн цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална. | "Цахим хэлбэрээр боловсруулалт хийх технологийг ашиглан мэдээлэл цуглуулж, боловсруулж, ашиглах үйл ажиллагаанд үнэлгээ хийх журам"-ыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн А/81 дүгээр тушаалаар баталсан. Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн санд бүртгүүлэх хүсэлтийг Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн 01/1771 дугаартай албан бичгээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж, бүртгүүлсэн.<br>Хавсралт : 1 файл | 100% | Тийм | Захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн бүртгэлийн 2023 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 6429 дугаарт бүртгэсэн. |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 17 | | 32 | | 25.1.1. хүний хувийн мэдээлэл хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж, олон нийтэд сурталчлан таниулах, холбогдох байгууллагатай хамтран ажиллах, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;<br>(25.1.Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага цахим орчинд мэдээлэл хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:) | Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны 09 дүгээр сарын 11-ний өдрийн А/90 дүгээр тушаалаар "Хүний эмзэг мэдээлэл, генетик болон биометрик мэдээлэл боловсруулахад баримтлах технологийн аюулгүй байдлын шаардлага, журам"-ыг баталсан.<br>Хавсралт : 1 файл | 100% | Тийм | Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд 2023 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн 6432 дугаарт бүртгэгдсэн. |
| 18 | | 39 | | 37.2. Энэ хуулийн 37.1-д заасан этгээд 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн дотор гэрээ шинэчлэн байгуулах хүсэлтийг цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлж, гэрээ байгуулна. | Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 11-ний 196 дугаар тогтоолоор батлагдсан "Үндсэн системийн үйл ажиллагаа зохицуулах, систем ашиглаж үйлчилгээ үзүүлэх, мэдээлэл солилцох журам"-ын дагуу өмнө гэрээ байгуулсан 171 байгууллагын хүсэлтийг хүлээн авч , гэрээг шинэчлэн байгуулсан. Мөн журмын дагуу шинээр холбогдох хүсэлт ирүүлсэн 50 хүн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулан, үйлчилгээг үндсэн систем, дэмжих системд холбосон. | 100% | Тийм | Ил тод байдлын шалгуур үзүүлэлттэй давхацсан тул хэрэгжилтээс хасуулах саналтай байна. |
| 19 | | 40 | | 8.19. Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журмыг Засгийн газар батална. | Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 352 дугаар тогтоолоор баталсан. | 100% | Тийм | Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 352 дугаар тогтоолоор баталсан тул хяналтаас хасуулах саналтай байна. Энэ тогтоолын хүрээнд тус яамнаас шил ажиллагаар хэрэгжүүлж дууссан.<br>https://legalinfo.mn/mn/detail?lawId=16531445101831 |
